

ХОХ

ХОХ тоглоомоор хоёр тоглогч тоглох ба нэг нь Х нөгөө нь О гэсэн дүрс авна. Тэд ээлж ээлжээр аль нэг хоосон дөрвөлжин нүдэнд өөрийн дүрсийг зурна. 3 x 3 хэмжээтэй хөлөг дээр тоглох үед хэн түрүүлж аль нэг мөр, багана эсвэл диагоналийг өөрийн дүрсээр дүүргэсэн нь хожно. Уг тоглоомын дэлхийн аварга шалгаруулах тэмцээний сүүлийн өрөг явагдаж байтал хоёр тамирчны цуснаас допинг илэрсэн тул тоглолтыг зогсоожээ. Тоглогч бүр гурав гурван нүүдэл хийж амжсан байсан байна. Иймд шүүгчид энэ дуусаагүй өрөг дээр хэн хожих байсныг тодруулах болжээ. Олон улсын ХОХ-ын холбооны дүрмээр бол хамгийн эхний нүүдлийг Х хийдэг. Хоёр тоглогч хоёулаа хамгийн зөв нүүдлүүдээ хийж тоглосон үед хэн нь хожихыг тодорхойл.

Input

Оролтын файлд тоглогч бүрийн гурав, гурван нүүдэл хийсний дараах өргийн байрлалыг үзүүлсэн хүснэгт байна. Латин цагаан толгойн Х, О-гоор тоглогчдын нүүдэл хийсэн нүднүүдийг тэмдэглэсэн ба # дүрсээр хоосон байгаа нүднүүдийг тэмдэглэнэ.

Output

Гаралтын файлд хэрэв Х-үүд хожих байсан бол Х үсэг, О-ууд хожих байсан бол О үсэг, тэнцэх байсан бол # тэмдэгтийг хэвлэнэ.

Example

Input:

ХХО

#Х#

#ОО

Output:

О